

## ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2017.09.25-2017.10.25/


### УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар Сумын төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийг “Орон нутгийн тусгай хамгаалалтанд авах” саналыг танилцуулж ИТХ-ын хуралдаанаар оруулахаар боллоо.

Сумын Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах комисс өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу албан байгууллага, аж ахуй нэгжүүдийн өвөлжилтийн бэлтгэл ажлуудад хяналт шалгалт хийж ажиллаа. Сумын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажил 93,3 хувийн гүйцэтгэлтэй байна.



Сумын хэмжээнд цэрэг татлагын ажлыг 10 сарын 18-ны өдөр зохион байгуулж 18-25 насны 47 иргэн хамрагдахаас 32 иргэн буюу 68,1%-ийн ирцтэй хамрагдаж 3 иргэн цэрэгт татагдсан байна.



Сумын төсвийн байгууллага болон томоохон аж ахуйн нэгж байгууллагуудад “Мэдээллийн цаг” зохион байгуулах удирдамжийг Сумын Засаг даргаар батлуулан Газрын харилцааны хууль тогтоомжийг сурталчилах, сумын газрын харилцааны

мэдээллийг хүргэн ажиллаж байна. Хуваарийн дагуу Илчлэг-Шивээ ОНӨҮГ-ын 15 албан хаагчдад мэдээлэл өгч ажиллаа.



Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг ГХГЗЗГазрын даргын 2015 оны А/105 тоот тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторинг хийх аргачлал”-ын дагуу Сэвхүүлийн говь, Эрдэнэтолгой, Зүүн хангай зэрэг газруудын бэлчээр ашиглалтын

өвөлжөө, хаваржаа, намаржаа, зунжааны 5 цэгээс дээж авч ажилласан.

Сумын авто машины гражуудын өгнө үзэмжийг сайжруулах ажлыг газар эзэмшигч иргэдтэй хамтран үе шаттайгаар зохион байгуулж 15 дугаар байрны зүүн талд байршилтай 24 ширхэг авто гражыг нэг өнгөөр будуулж дугаартай болгосон.



## **ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ**

2017 оны 10-р сарын 25-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

<b>№</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Санхүүжилт /мянган.төг/</b>	<b>Зардлын гүйцэтгэл /мянган.төг/</b>
1.	ИТХ	33 553 800	33 307 309
2.	ЗДТГ	212 073 700	209 807 611

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

<b>№</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>Санхүүжилт /мянган.төг/</b>	<b>Зардлын гүйцэтгэл /мянган.төг/</b>
1.	Эрүүл мэндийн төв	244 852 500	242 240 428
2.	Соёлын төв	44 003 500	42 153 500
3.	3-р сургууль	666 981 300	638 002 500
4.	3-р цэцэрлэг	314 594 100	295 724 600

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 46840,0 мянган төгрөг бөгөөд 10-р сарын 25-ны байдлаар нийт 34534,9 мянган төгрөг буюу 73,7 хувийн биелэлттэй байна.

## **ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ**

Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн мэдээг гаргаж ТЗУХ-т хүргүүлсэн. Үүнд:

2017 оны 3-р улирлын байдлаар Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 51 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 568 нийт 619 өргөдөл хүлээн авсанаас 614 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

Аймгийн Хууль эрх зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран Зөрчлийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж 108 иргэн хамрагдаж 432 ширхэг гарын авлага тарааж ажилласан байна.



Сумын 18-25 насны залуучуудад Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж 25 залуучууд хамрагдсан. Мөн цэргийн албаны тухай хуулиар гарын авлага бэлтгэж тараасан.


### **БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ:**

#### **3-Р АХЛАХ СУРГУУЛЬ**

“Номын баяр”-ын өдөрлөгийг 2017 оны 09-р сарын 27 өдөр зохион байгуулж сургуулийнхаа номын сангийн үйл ажиллагааг сурталчлах, шинэ номын үзэсгэлэн, хамгийн их уншигдсан 10 номыг шалгаруулах зэрэг ажлуудыг аймгийн төв номын сантай хамтран зохион байгууллаа.



Улсын төсвийн 103,3 сая төгрөгийн хөрөнгөөр 3-р сургуулийн барилгын дээврийн засварын ажлыг Цахир толгойн орд ХХК хийж гүйцэтгэж улсын комисст хүлээлгэн өглөө.



Говьсүмбэр аймгийн 4 гавьяатын “Мэргэжил бүхэн сайхан” уулзалт ярилцлагыг 2017 оны 10 дугаар сарын 12-нд 3-р сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 78 сурагч хамрагдлаа.



Сумын 3-р сургуулийн нийгмийн ухааны багш Г.Зоригт “Тагтаат цэнхэр алчуур” өгүүллэгийн номын баяраа 2017 оны 10-р сарын 05-нд хийлээ.

3-р сургууль нь сурагчдын тав тухтай орчин нөхцлийг бүрдүүлэх зорилгоор өөрсдийн нөөц бололцоог ашиглан дотуур байрны засварын ажлуудыг хийж гүйцэтгэн 10-р сарын 09-ний өдрөөс сурагчдаа хүлээн авч 35 сурагч байрлаад байна.



Сумын “Хүүхдийн чуулган”-ыг 3-р сургуулийн хүүхдийн зөвлөлийн 40 гаруй сурагчийн баг 2017 оны 10 сарын 21-ний өдөр зохион байгуулж, 200 гаруй хүүхэд оролцож, хүүхдийн хөгжил оролцоо, харилцаа хандлага, эрх үүргийн талаар өртөөчилсөн сургалтуудыг зохион байгуулсан. Чуулганы үеэр сумын Шилдэг сурагчдад шагнал гардууллаа.



## **СОЁЛЫН ТӨВ**

Сумын хэмжээнд байдаг түүхийн дурсгалт газар болон, булаг шандны эхийг сэргээн засварлах ажлыг жил бүр зохион байгуулж энэ жил “Зуун эхийн умай” түүхийн дурсгалт газрын ойр орчмын хогийг цэвэрлэж, өнгө будгийг сэргээн засварлалаа. Мөн Нэртийн булаг, Бэхтийн булаг зэрэг уст цэгийн ойр орчмын хог хаягдалыг цэвэрлэж талбайн солбилцол зэргийг авч баримтжууллаа.

Аймгийн Соёл, урлагийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд номын санд 2438000 төгрөгийн 216 ширхэг номоор баяжилт хийгдсэн. Эдгээр номын ном зүйн техник ажиллагаануудыг хийж уншигч үйлчлүүлэгчдэдээ хүргээд байна. 2017 оны 10-р сарын 19-ны өдрийн байдлаар нийт ном олголтын тоо 9757, уншигчдийн тоо 5413 болж өслөө.

Номын сангийн үйлчилгээг иргэд, үйлчлүүлэгчид болон хүүхэд багачуудад хүргэхийн тулд ангийн уншлага болон багачуудад үлгэрийн цагийг хүргэн ажиллаж байна.



Говьсүмбэр аймгийн дуу бүжгийн Боржигон чуулгын “Хувьтай нутаг” уран бүтээлийн тоглолт, “Пороро ба түүний найзууд” тоглолтууд 2017 оны 10-р сарын 20-ны өдөр зохион байгуулагдлаа.



Аймгийн Ураг удам, уламжлал, Угийн бичгийн сургалтын төвийн тэргүүн Д. Цогбадрах гуайг урин “Угийн бичиг”-ийн сургалтыг сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулж 135 иргэд хамрагдлаа.



Сумын соёлын төв нь мини кино театраар “Зүрхний хилэн” Монголын уран сайханы шинэ киног 2017 оны 10-р сарын 21-22 өдрүүдэд гарган 84 иргэн үзэж сонирхосон байна.

## **ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

Эрүүл мэндийн төвд 48 өвчтөн хэвтэж үүнээс хүүхэд-12, дотор- 36 хэвтэн эмчлүүлж байна.

Эмнэлгийн үйлчилгээ нь:

Урьдчилан сэргийлэх –273

Дуудлага-142

Амбулаторийн үзлэгт- 654 иргэн хамрагдсан байна.

Сумын ЭМТ-ийн эх баригч, бага эмч “Жирэмсэн эмэгтэйчүүдийн дасгал” сэдэвт сургалтыг 10 сарын 12-ны өдөр жирэмсний хяналтанд байгаа эхчүүдийн дунд зохион байгуулсан байна. Мөн жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналт, Манас таталт сэдвээр их эмч нарт сургалт зохион байгуулан ажилласан.





“Бүх нийтээрээ алхая” дэлхийн алхалтын өдрийг 10 сарын 13-ны өглөөний 07 цагаас 07:30-ийн хооронд тэмдэглэн өнгөрүүллээ Дэлхийн алхалтын өдөрт 8 байгууллагын 49 ажилтан хамрагдсан байна. Нийт ажилчид сумыг бүтэн тойрч алхан, гадаа талбайд өглөөний дасгалыг хийж зөв алхалтын талаарх мэдээлэл гарын авлагаар хангагдсан.



Эрүүл мэндийн төвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан 2017 оны 10 сарын 04, 12-ны өдрүүдэд ЗДТГ болон Эрүүл мэндийн төвийн ажилтан, албан хаагчдад “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.



## УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 92 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 21 иргэн бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

10-р сард газраа анх удаа өмчилж авахаар 3 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг 79 иргэнд олгоод байна.

Иргэдээс 10 сард 58 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

## **ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2017 ОНЫ 10 САРЫН МЭДЭЭ**

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	68				68	40	28
Төрсөн эх	2	68				68		68
Бүртгүүлсэн гэр бүл	3	12				12	12	12
Нас баралт	4	14				14	9	5
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	0				0	0	0
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	103				103	49	54
Аймаг, нийслэл рүү шилжин	8	78				78	36	42

явсан								
-------	--	--	--	--	--	--	--	--

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС  
ОРСОН ОРЛОГО**

2017.10.23.

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2017 оны 10-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 30020002297 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
2	Эцэг тогтоолт	2500	5	12500				
3	Гэрлэлтийн бүртгэл	2500	1	2500				
4	өөр аймаг шилжин явсан	2500	2	5000	1000	2	2000	
5	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	2	3000	1000	2	2000	
6	Сум доторх шилжилт хөдөлгөөн	1500	5	7500	1000	35	5000	
7	Иргэний үнэмлэх	15000	21	315000	3300	21	69300	
<b>ДҮН</b>		<b>345500</b>			<b>78300</b>			
<b>НИЙТ ДҮН</b>		<b>423800</b>						

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ**

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 3 удаа зохион байгуулж 25 иргэний өргөдлийг шийдвэрлэсэн. Үүнд:

1. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа иргэнд сар бүр олгодог асаргааны мөнгөн тэтгэмжийн сунгалтанд 11 иргэн

2. Байнгын асаргаа шаардлагатай 16–ээс дээш насны иргэнд сар бүр олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалтанд 9 иргэн

3. Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртлэх насны хүүхдэд сар бүр олгодог амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн сунгалтанд 2 иргэн

4. Тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд жилд нэг удаа олгодог түлээ нүүрсний хөнгөлөлтийн мөнгөн тусламжид 3 иргэн тус тус хамрагдсан.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй өрх, өрх толгойлсон эмэгтэй болон сумын зорилтот бүлгийн 25 иргэнд “Гэр бүлийн баяр хөөр”, “Өрхийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх, хуримтлал бий болгох” сэдэвт сургалтуудыг аймгийн “Шинэ хөгжлийн түлхүүр” ТББ –тай хамтран 2017 оны 09-р сарын 20-24-ны өдрүүдэд зохион байгууллаа.



Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу бүрэн хараагүй, хэлгүй дүлий, одой иргэн болон байнгын асаргаа шаардлагатай хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй 27 иргэнийг түлээ, нүүрсний хөнгөлөлтөнд хамруулж 3780000 төгрөгийн мөнгөн тусламжийг олгосон. Үүнд:

1. Бүрэн хараагүй – 6 иргэнд 840000 төгрөг
2. Хэлгүй дүлий – 2 иргэнд 280000 төгрөг
3. Байнгын асарага шаардлагатай – 9 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1260000 төгрөг
4. Хөгжлийн бэрхшээлтэй – 10 хүүхдэд 1400000 төгрөг



Сумын 2 ахмад настан, 2 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд даралтын аппарат, ярьдаг халууны шил, радио хүлээн авагч,

цагаан таяг, хөтөвч, тохойвчтой хос таяг зэрэг нийт 510000 төгрөгийн хөнгөлөлтийг үзүүллээ.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааны баталгаажуулалтын ажлыг 2017 оны 10-р сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулж нийт 310 өрхөөс 290 өрхийн мэдээллийг баталгаажуулж 10-р сарын 24 өдрийн байдлаар 93,5 хувийн хэрэгжилттэй ажиллаж байна.

“Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ”-нд хамрагдаж байгаа 8 өрхийн 10-р сарын хүнсний эрхийн бичгийг олгож гэрээ байгуулсан дэлгүүрээр дамжуулан 474500 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг олгоод байна.

Шивээ-Овоо ХК-ийн ажлын байрны захилагын дагуу нийт 20 иргэнийг ажил зуучлан 8 иргэнийг түр, 12 иргэнийг байнгын ажлын байртай болгоод байна.

### **НИЙГМИЙН БОДЛОГО**

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын 3 төрлийн тэмцээнийг 2017 оны 09 сарын 26-ны өдөр Хаялга нуурын эрэг дээр зохион байгууллаа.



Аймгийн “Аялал жуулчлалыг хөгжүүлэх” дэд хөтөлбөр, Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр, Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд сумын зорилтот өрхүүдэд аймгийн аялал жуулчлалын холын маршрутыг танилцуулах, жендерийн тухай ойлголт хандлагыг түгээх зорилгоор “Байгаль бидний гэр” гэр бүлийн аялалыг 09 сарын 29-нд зохион байгуулж 10 өрх хамрагдлаа. Аялалын хүрээнд өртөө болгоныг танилцуулж жендерийн эрх тэгш байдал, гэр бүлийн хүчирхийллийн тухай

хуулийн талаар мэдээлэл өгч, гэр бүлийн дунд 3 төрлийн тэмцээнийг зохион байгууллаа. Мөн Шивээговь сумын аялал жуулчлалын цэг болох Хаялга нуурын эргийн цэвэрлэгээг зохион байгуулж, хогийн цэг болон нуурын танилцуулах самбарыг хийж байрлуулсан.



Сумын “Амад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Ахмадаа хүндэлье” аяныг 2017 оны 09-р сарын 12-ноос 10-р сарын 01 хооронд зохион байгууллаа. Аяны хүрээнд:

- “Хариу нэхээгүй тус” аянд ЗДТГ-ын ажилтан, албан хаагчид, 3-р сургуулийн 9 бүлгийн сурагчид хамрагдаж, ганц бие болон хүнд өвчтэй 10 ахмадуудад бүтээлч ажил хийж, баярлууллаа.



- 4 байгууллага “Ахмадын сургааль алт” ярилцлага зохион байгуулж, суманд үйл ажиллагаа явуулдаг нийт 36 байгууллага, аж ахуйн нэгж харьяалсан 201 ахмададаа хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардууллаа.



- Сумын Ахмадын хороо, Соёлын төвтэй хамтран ахмадуудын дунд “Бид угийн бичгээ өвлүүлэн үлдээгчид” хөдөлгөөн өрнүүлж, Шилдгүүдээ шалгарууллаа.

- Олон улсын ахмадын баярын арга хэмжээг 10 сарын 01-ний өдөр зохион байгуулж хүлээн авалт хийж, ахмадуудын дунд 3 төрлийн тэмцээн, уралдаан зохион байгуулж 97 ахмад настан хамрагдлаа.



Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд байгаль орчныг хамгаалах үйлсэд хувь нэмэр оруулж байгаа 6 ахмад настанд чацаргана, үхрийн нүдний тус бүр 10 модны суулгац олголоо.



## **БАЙГАЛЬ ОРЧИН**

Бүх нийтийн их цэвэрлэгээг хуваарийн дагуу 10 сарын 13-ны өдөр зохион байгуулж 15 аж ахуй нэгж байгууллагын 53 ажилтан албан хаагч хамрагдаж  $8,3\text{м}^3$  хог хаягдлыг цэвэрлэж төв хогийн цэгт ачиж зайлуулсан.



АБ, ААН айл өрхөөс хог хаягдал гаргасны төлбөрийг хураан авах ажлыг эрчимжүүлэн ажиллаж 10-р сарын 20-ны байдлаар ОНО-д хог хаягдлын хураамж 5,290,000 төгрөгийг төвлөрүүлээд байна.

## **ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ**

“Иргэдийг малжуулах журам”-ын дагуу 10 дугаар сарын 4, 5-ны өдрүүдэд амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 4 малчин өрхөд тус бүр 38



хонь, 18 ямааг гэрээгээр хүлээлгэн өгч цөөн мал бүхий өрхийг малжуулах ажлыг зохион байгуулсан.



Сумын Засаг даргын А/105 дугаар “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тухай” захирамжийн дагуу 10 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн вакцинжуулалтын ажлыг зохион байгуулж 10-р сарын 23-ны өдрийн байдлаар 55 өрхийн 34795 толгой мал хамрагдаад байна.

Бэлчээрийн хортон мэрэгчийн тандалтын судалгааг 2017 оны 10 дугаар сарын 06-нд Эрдэнэтолгой, Зүйтийн тал, Тогоо булагт тус тус нийт 5000 га талбайд явууллаа.


Судалгааны дүнд Зүйтийн тал, Тогообулагт оготны тархалт олширсон, Эрдэнэтолгойд шигүү хэмжээнд байгаагаас үзэхэд сумын хэмжээнд бэлчээрийн хортон мэрэгч болох үлийн цагаан оготны тархалт олширсон тэмцэх шаардлагатай байна.



Сумын 2 дугаар багийн малчинтай байгуулсан гэрээний дагуу бог малын хээлтүүлэгчийг эх сүргээс нь ялган суурилуулж намрын хянан баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, хуц, ухныг малчин өрхүүдэд тараах ажлыг зохион байгуулсан.



Төмс 2,3 га талбайд тариалж 21,19 тн ургац, хүнсний ногоо 5,87 га талбайд тариалж 77,67 тн ургац хураан авсан нь өмнөх оныхтой харьцуулахад 12,6 тн ургацаар өссөн үзүүлэлттэй байна.



Хүнсний гол нэрийн барааны үнэ сумын төвийн томоохон худалдааны төвүүдэд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар дараах үнэтэйгээр худалдаалагдаж байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ/төг/	Доод үнэ/төг/
1	Үхрийн мах	Ястай	5500
		Цул	6000
2	Хонины мах	Ястай	4500
		Цул	5500
3	Адууны мах	Ястай	5000
		Цул	5500
4	Ямааны мах	Ястай	4000
		Цул	4500
5	Тахианы мах	Гуя	7500
		Мөч	7500
6	Лууван	Монгол	1300
		Хятад	1200

7	Төмс	Хятад		
		Монгол	1100	800
8	Байцаа	Монгол		1400
		Хятад	1300	
9	Чинжүү	Монгол		
		Хятад	6000	5500
10	Манжин	Монгол	1500	1000
		Хятад		
11	Сонгино /бөөрөнхий/	Монгол	2200	1800
		Хятад	1300	1200
12	Помидор	Монгол	6000	5500
13	Өргөст хэмх	Монгол	6500	4000
14	Элсэн чихэр		2300	2200
15	Будаа	Цагаан задгай 1кг /хятад/	2400	2200
		Шар слава 1кг	1700	1500
		Гурвалжин слава 1 кг	3600	3500
16	Сүү	Задгай		
		Сүү ХК 1л 3.2% тослогтой	2700	2500
17	Тараг	Задгай		
		Сүү ХК 1л 3.2% цэцгийтэй	2750	2350
18	Талх	Чойр /Шивээ/	1000	900
19	Өндөг	ОХУ		
		Монгол	350	300
20	Алтан тариан гурил	Задгай дээд		
		Задгай 1-р зэрэг		1150
		Задгай 2-р зэрэг		900
		Савлагдсан д/дээд	1700	1650
		Савлагдсан дээд	1450	1350
		Савлагдсан 1-р зэрэг	1200	1150
		Савлагдсан 2-р зэрэг	1000	900
21	Ургамлын тос	Олейна	4400	
22	Гоймон	Алейка	900	
		А/т савхан	900	850

### **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**

Сумын Засаг даргын 2017 оны 09-р сарын 19-ны өдрийн А/101 тоот захирамжаар нохой устгах арга хэмжээний шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсэг томилогдон 2-р багийн иргэнтэй гэрээ байгуулан нохой устгах ажлыг зохион байгуулж 82 нохой, муур устгаж ариутгал хийж шатаасан.



ОНХС-ийн 3,5 сая төгрөгийн хөрөнгөөр 3-р сургуулийн сантехникийн засварын ажлыг шууд худалдан авалтын ажлын хэсэг шалгаруулалт хийж, иргэн Г.Батсайхантай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж хүлээн авсан.

